



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

Комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Захирагчийн Ажлын Албатай зөвшилцсөнөөр Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт Авто пүү хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Баруун салбарын дарга	/Б.Нямсүх/
Гишүүд:	ЗАА-ны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Эмнэлгийн болон аюултай хог хаягдал хариуцсан мэргэжилтэн	/С.Аригуун/
	ЗАА-ны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Хог хаягдлын үйлдвэрлэл, боловсруулалт, төвлөрсөн хогийн цэг хариуцсан мэргэжилтэн	/Т.Энх-Амгалан/
	Талбайн хяналтын инженер	/П.Цэрэннадмид/
	Ахлах мэргэжилтэн	/Р.Ганбат/
	Тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа хариуцсан инженер	/Ч.Манлайбаатар/
	Аж ахуйн үйлчилгээний мэргэжилтэн	/Ж.Ганбаатар/
Нарийн бичгийн дарга:	Нярав	/Л.Цэрэндагва/

2. Комиссыг шуурхай ажиллуулж, үр дүнг удирдлагуудад танилцуулахыг Комиссын дарга /Б.Нямсүх/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер бөгөөд Шуурхай удирдлагын төвийн дарга /С.Баяр-Өлзий/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Б. ГАНЗОРИГ



D:\TUSHAAL\A tushaal.docx

2130300107



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 1/35

Улаанбаатар хот

Ажил хариуцуулан томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Драгон худалдааны төвийн зүүн талд байрлах Нийслэлийн Үйлчилгээний Нэгдсэн Төвийн гаднах тохижилт, гэрэлтүүлэг, авто зогсоол байгуулах авто замын барилга угсралтын ажлын Талбайн инженерээр Баруун салбарын Хэсгийн талбайн инженер Цэрэнгийн Хүрэлчулууныг, Барилгын даамлаар Зам барилга, ашиглалт засварын инженер Отгонхишигийн Буянтогтохыг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженерээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер Балдандоржийн Тунгалагийг тус тус томилсугай.
2. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер бөгөөд Шуурхай удирдлагын төвийн дарга /С.Баяр-Өлзий/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ГАНЗОРИГ



**НИЙГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 06 сарын 22 өдөр

Дугаар A/56

Улаанбаатар хот

Ажил гүйцэтгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ази-Европын дээд түвшний 11 дэх удаагийн уулзалтын бэлтгэл ажлыг хангахтай холбогдуулан, үерийн хамгаалалтын далан сувгийн лаг цэвэрлэгээний ажлыг 2016 оны 06 дугаар сарын 30-нд багтаан гүйцэтгэж дуусгасугай.

2. Баруун салбарын үерийн хамгаалалтын далан сувгийн лаг цэвэрлэгээний ажлын төсвийн зардлын задаргааг 1 дүгээр хавсралтаар, Зүүн салбарын үерийн хамгаалалтын далан сувгийн лаг цэвэрлэгээний ажлын төсвийн зардлын задаргааг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Төсвийн зардлын задаргааны дагуу машин механизм, тээврийн хэрэгсэл, ажилчдын цалинг 8 909 772 /Найман сая есөн зуун есөн мянга долоон зуун далан хоёр/ төгрөгт багтаан ажиллуулахыг Баруун салбарын авто баазын Ерөнхий инженер О.Лувсандагвад, 8 077 748 /Найман сая далан долоон мянга долоон зуун дөчин найман/ төгрөгт багтаан ажиллуулахыг Зүүн салбарын авто баазын Инженер, эдийн засагч Н.Ууганбаярт, инженер техникийн ажилтан, ажилчдын цалингийн шууд зардлыг 19 616 443 /Арван есөн сая зургаан зуун арван зургаан мянга дөрвөн зуун дөчин гурван/ төгрөгт багтаан ажиллуулахыг Баруун салбарын 3 дугаар хэсгийн инженер Д.Ариунбаатарт, 16 419 990 /Арван зургаан сая дөрвөн зуун арван есөн мянга есөн зуун ерэн/ төгрөгт багтаан ажиллуулахыг Зүүн салбарын 5 дугаар хэсгийн инженер С.Батсайханд нарт тус тус даалгасугай.

4. Дээрх төсвийн задаргааны дагуу тооцоог хийж, бүртгэл хөтлөхийг Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга /Б.Мөнх-Оргил/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ГАНЗОРИГ



2130300111



**НИЙГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 06 сарын 24 өдөр

Дугаар A/57

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын хэсэгт орсон байсан зарим ажилтнууд ажлаас чөлөөлөгдсөн учир 2016 онд гүйцэтгэх авто зам, замын байгууламжийн засвар, тоноглол, гэрэлтүүлэг, цахилгаан шугам сүлжээ, тэмдэг тэмдэглэгээний ажилтай холбоотой ажил, үйлчилгээ гүйцэтгэх туслан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	С.Баяр-Өлзий	/Ерөнхий инженер бөгөөд Шуурхай удирдлагын төвийн дарга /
Гишүүд:	Ц.Ганбаатар	/Баруун салбарын дарга/
	Л.Оюунжаргал	/Зүүн салбарын дарга/
	Д.Мөнх-Эрдэнэ	/Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч/
	Д.Ганболд	/Үйлдвэрлэлийн баазын дарга/
	Ж.Батболд	/Зам барилгын ахлах инженер/
Нарийн бичгийн дарга:	З.Оюунцэцэг	/Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн/

2. Сонгон шалгаруулалтын ажлыг зохих хууль, журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн дарга /С.Баяр-Өлзий/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/33 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ГАНЗОРИГ

2130300113



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн боловсруулж, удирдлагад танилцуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:	С.Баяр-Өлзий	/Ерөнхий инженер бөгөөд Шуурхай удирдлагын төвийн дарга /
Гишүүд:	С.Майнбаяр	/Үйл ажиллагаа дэмжих асуудал хариуцсан Орлогч дарга/
	Л.Оюунжаргал	/Зүүн салбарын дарга/
	Ц.Ганбаатар	/Баруун салбарын дарга/
	Б.Мөнх-Оргил	/Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга/
	Д.Батмягмар	/Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга/
	Д.Мөнх-Эрдэнэ	/Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч/
	Я.Нармандах	/Дотоод хяналтын албаны дарга/
	Ш.Сүхбаатар	/Хангамж, аж ахуйн албаны дарга/
	Д.Ганболд	/Үйлдвэрлэлийн баазын дарга/
Нарийн бичгийн дарга:	Б.Нарантуяа	/Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн/

2. Байгууллагын бүтцийн зураглал, үйл ажиллагааг ханган ажиллахад шаардлагатай орон тоог зөв оновчтой тодорхойлон гаргахыг Ажлын хэсгийн дарга /С.Баяр-Өлзий/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ГАНЗОРИГ

2130300115



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 06 сарын 30 өдөр

Дугаар A/60


Улаанбаатар хот

Тамирчдын өдрийг тэмдэглэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Биеийн тамир спортын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тамирчдын өдөр-2016" баярыг байгууллагын ажилтнуудын дунд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.
2. Дээрх баярыг тэмдэглэх ажлын хүрээнд харьяа байгууллагуудын дунд зохион байгуулдаг тэмцээнүүдэд спортын амжилт гаргасан ажилтнуудад дурсгалын зүйл гардуулахад шаардагдах 200 000 /Хоёр зуун мянган/ төгрөгийг нийгмийн арга хэмжээний зардлаас тооцон гаргахыг Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга /Б.Мөнх-Оргил/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ГАНЗОРИГ



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 07 сарын 06 өдөр

Дугаар A/61

Улаанбаатар хот

Болзолт уралдаан зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажилчдын идэвх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, хэсгийн зохион байгуулалт, ажлын бүтээлч шинэ санал санаачлагыг дэмжих зорилгоор 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 2016 оны 08 дугаар сарын 20-ны өдрүүдэд нийт 13 хэсгийн хооронд болзолт уралдаан зарласугай.
2. Болзолт уралдааныг зохион явуулах удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Болзолт уралдааны шагналын санд шаардагдах нийт 6 000 000 /Зургаан сая/ төгрөгийг Нийгмийн арга хэмжээний зардлаас тооцон гаргахыг Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Д. Мөнх-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга /Б.Мөнх-Оргил/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭНХСАЙХАН

2130300121



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Үндэсний их баяр наадмын өдрүүдэд
ажиллах ажилтнуудын ажлын хуваарь батлах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний их баяр наадмаар ажилтнуудын хөдөлмөр зохион байгуулалтыг зөв оновчтой хийж, гарсан асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авч хариуцлагатай ажиллахыг салбар, хэсгийг хариуцан ажиллах удирдах албан тушаалтан, ажилтнуудад үүрэг болгосугай.
2. Баярын өдрүүдэд ажиллах ажилтнуудын нэр, ажиллах өдөр, цагийн хуваарийг 1 дүгээр хавсралтаар, цэвэрлэгээ, усалгааны тусгай зориулалттай машин механизмын ажиллах хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, хуваарийг мөрдөн ажилласугай.
3. Ажилтнуудын ажилласан цагийн бүртгэл, хоолны мөнгөний тооцоо хийж, хяналт тавьж ажиллахыг салбар, хэсгийн удирдлагуудад үүрэг болгосугай.
4. Баярын өдрүүдэд гарсан зардлуудыг зохих журмын дагуу тооцон олгохыг Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Д. Мөнх-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шуурхай удирдлагын төвийн дарга бөгөөд Ерөнхий инженер /С.Баяр-Өлзий/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭНХСАЙХАН

2133330123